

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/27/НА-СТА-ОНА

Цахим хуудас: [www.audit.mn](#)

Улаанбаатар хот

2023 он

“Ашид баланс аудит” ХХК-ийн захирал Л.Майцэцэг  
Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтанцэцэг  
Утас: 99178619 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Туслах аудитор: Д.Сэрчинмаа  
Утас: 99265037 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Идм. ДЗ. 15

№

647

танай

-ны №

-т

УЛААНБААТАР ШИНЭ БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Г.МИШЭЭЛТ ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

НИТХ-ын 2022 оны 115 дугаар тогтоолоор Нийслэлийн 2023 оны төсвөөс Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн үйл ажиллагааны зардалд 3,470,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг баталснаас тус ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар тогтоолоор төсвийн сар, улирлын зардлын хуваарийг баталсан байна.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/77 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам” барих төслийн баригдах Туулын 33 км, хойд чиглэлийн 55 км авто зам, гүүр, хиймэл байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах 3,120,977.2 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-д шилжүүлсэн байна. Уг зөвлөх үйлчилгээний тендерт 1,962,058.1 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлсэн “ХТЗ авто зам” ХХК шалгарч, гэрээ байгуулсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус компани нь Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тайлант онд 4 зорилт, 27 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан бөгөөд хэрэгжилтийг 94.07 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

А Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>У</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>Д</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
<b>И</b>	Кассад байгаа бэлэн мөнгө		
<b>Т</b>	Төгрөг		
	Банканд байгаа бэлэн мөнгө		
<b>Х</b>	Төгрөг		
<b>И</b>	Арилжааны банк дахь харилцах		
<b>Й</b>	<b>АВЛАГА</b>		
<b>С</b>	Бусад авлага		
<b>Э</b>	Ажиллагсадтай холбоотой авлага		
<b>Н</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		
	Урьдчилж гарсан зардал		
<b>С</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
<b>а</b>	Хангамжийн материал		
<b>н</b>	Бичиг хэргийн материал		
<b>х</b>	Аж ахуйн материал		
<b>Ү</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>Ү</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
<b>Г</b>	Биет хөрөнгө		
<b>И</b>	Машин тоног төхөөрөмж(компьютер)		
<b>Й</b>	Хуримтлагдсан элэгдэл	(	(
<b>н</b>	Тавилга, аж ахуйн эд хогшил		
<b>б</b>	Хуримтлагдсан элэгдэл		
<b>а</b>	Биет бус хөрөнгө		
<b>й</b>	Програм хангамж		
<b>д</b>	Хуримтлагдсан элэгдэл		
<b>л</b>	Бусад биет бус хөрөнгө		
<b>ы</b>	Хуримтлагдсан элэгдэл		
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Т</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>а</b>	Өглөг		
<b>й</b>	Ажилчидтай холбогдсон өглөг		
<b>л</b>	ААНОАТ өглөг		
<b>а</b>	НӨАТ өглөг		
<b>н</b>	Бусад өглөг		
	Байгууллагад төлөх өглөг		
	Урьдчилж орсон орлого		
	Бусад урьдчилж орсон орлого		
	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		
	Засгийн газрын хувь оролцоо		
	Хуримтлагдсан үр дүн		
	Тайлант үеийн үр дүн		
	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
	Борлуулалтын орлого/цэвэр/		
	Борлуулалтын өртөг		
	<b>Нийт ашиг/алдагдал/</b>		
	Санхүүжилт орлого		
	Хүүгийн орлого		
	Бусад орлого		
	Ерөнхий ба удирдлагын зардал		
	Бусад зардал		
	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/</b>		
	Орлогын татварын зардал		
	<b>Татвар дараах ашиг/алдагдал/</b>		
	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хуримтлагдсан ашиг/алдагдал	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		
Залруусан үлдэгдэл		
Тайлант үеийн ашиг, алдагдал		
<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>		
Залруусан үлдэгдэл		
Тайлант үеийн үр дүн		
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Татаас санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		
	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
	Ажиллагчдад төлсөн		
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
	Бараа материал худалдан авахад төлсөн		
	Ашиглалтын зардалд төлсөн		
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зардал		
	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		
	Хүлээн авсан хүүгийн орлого		
	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

б  
о  
л  
с  
о  
н

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны			Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих					
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих					
<b><u>Нийт орлого</u></b>						
	Цалин					(
	НДШ					(
	Байр ашиглалтын зардал					( )
	Бичиг хэрэг					(
	Шуудан холбоо					(
	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс					( )
	Багаж, техник, хэрэгсэл					( )
	Тавилга					
	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл					( )
	Урсгал засвар					
	Томилолтын зардал					
	Зочин төлөөлөгч хүлээн авах					( )
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ					( )
	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох					( )
	Мэдээлэл технологийн зардал					( )
	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж					( )
	Бараа үйлчилгээний бусад зардал					( )
	Хичээл үйдвэрлэлийн дадлага хийх					( )
	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол					
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал					( )
	<b><u>Үйл ажиллагааны зардал</u></b>					{
	<b>Татварын өмнөх ашиг</b>					
	<b>Цэвэр ашиг</b>					
	Нийт авлага					

	Нийт өглөг				
	Үүнээс: Богино хугацаат өглөг				
	Нийт ажиллагсдын тоо			(20)	53.5
	Нийт цалингийн сан			(1,164,785,506.00)	
	Нэг ажиллагчийн дундаж цалин			(573,726.00)	

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 260,880.9 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Борлуулалтын орлогын нягтлан бодох бүртгэл тайланд НӨАТ-тэй дүнгээр бүртгэж, орлогыг 112,958.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Орлогын дэлгэрэнгүй тайланд тусгайлсан хувь хэмжээний харилцах дансны хүүгийн 39,506.1 мянган төгрөгийн орлого, гэрээний торгуулийн 2,547.2 мянган төгрөгийн орлогыг борлуулалтын орлогоор бүртгэж тайлагнасан;
- Тоног төхөөрөмжийн орлогыг бүртгэхдээ 902.1 мянган төгрөгийн НӨАТ-ыг авлагаар бүртгээгүй;
- Урсгал зардлын НӨАТ-ыг авлагаар бүртгээгүйгээс 7,060.0 мянган төгрөгөөр зардал нэмэгдүүлсэн;
- Шинэ тойрог замын төслийн судалгаа, тооцооллын 87,750.0 мянган төгрөгийн зардлыг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн;
- Залруулга хийгдсэнээр НӨАТ өглөг 1,482.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн.
- Залруулга хийгдсэнээр ААНӨАТ-ин өглөг 8,674.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Аудитаар нийт 3,418.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,418.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Шинэ тойрог замын төслийн санхүү, эдийн засаг үр өгөөжийг урьдчилан тооцоолох, шинээр баригдах авто зам, замын байгууламжийн концепц дизайн 3D загвар боловсруулах ажил гүйцэтгүүлэх гэрээг 1 иргэн, 1 ААНБ-тай байгуулахдаа гэрээнд НӨАТ-тэй дүнгээр гэж заасны дагуу төлбөрийг шилжүүлсэн бөгөөд уг иргэн, хуулийн этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдээгүй тул 3,418.2 мянган төгрөг илүү төлсөн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үнийн зөрүүг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

#### 5.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Гадаад томилолтын зардлыг ажилтанд тооцоо үүсгэж бүртгэж байгаа боловч анхан шатны баримтыг үндэслэн томилолтын тооцоог хийж баталгаажуулдаггүй, шууд зардлаар бүртгэж байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гадаад томилолтын дараа тайлангийн тооцоог анхан шатны баримтыг үндэслэн хааж, гүйцэтгэлээр холбогдох зардлын дансанд бүртгэж байх.

## 2. НБББББ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тэнцвэр консалтинг центр ХХК-тай 2023 оны 5 дугаар сарын 26-нд УБШББ/2023/02-01 дугаартай гэрээ байгуулан хийлгэсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, төсвийн байгууллагын бүртгэлээр боловсруулсан, компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь батлаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2.2. "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", Компанийн дүрмийн 7 дугаар зүйл "Төлөөлөн Удирдах зөвлөл" 7.3.5 "компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах" гэсэн заалт заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ыг хийсэн компаниар дээрх бичиг баримтад байгууллагын статус болон үйл ажиллагааны чиг үүрэгт тохирсон байхаар засвар өөрчлөлт хийлгэж, компанийн дүрмийн дагуу ТУЗ-ын шийдвэр гаргуулж батлуулах.





**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	ТШЗ	-	-	-	-	-	-	-	-
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	1	1	-	-	1	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 64 / 10810479

Улаанбаатар хот

ИТАГ - 2024 / 27 / ИА-СТА-ОНА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинэ тойрог замын төслийн санхүү, эдийн засгийн үр өгөөжийг урьдчилан тооцоолох, шинээр баригдах авто зам, замын байгууламжийн концепц дизайн 3D загвар боловсруулах ажил гүйцэтгүүлэх гэрээг 1 иргэн, 1 ААНБ-тай байгуулахдаа гэрээнд НӨАТ-тэй дүнгээр гэж заасны дагуу төлбөрийг шилжүүлсэн бөгөөд уг иргэн, хуулийн этгээдүүд нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдээгүй тул 3,418,181.82 (гурван сая дөрвөн зуун арван найман мянга нэг зуун наян нэгэн төгрөг, наян хоёр мөнгө) төгрөгийн НӨАТ-ыг илүү төлсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн гэрээгээр ажил гүйцэтгэсэн иргэн, аж ахуйн нэгжид илүү олгосон нийт 3,418,181.82 (гурван сая дөрвөн зуун арван найман мянга нэг зуун наян нэгэн төгрөг, наян хоёр мөнгө) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь ИТАГ. хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн захирал Г.Мишээлт, ерөнхий нягтлан бодогч Н.Одбаяр нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:**

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА,  
АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН:

Л.МАЙЦЭЦЭГ

Х.ТҮВШИНБАЯР  
С.ГАНТӨГС

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002051002